

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО” ДАХЬ ХЭЛЦ ХЭЛЛЭГ БҮХИЙ ӨГҮҮЛБЭР

Д.Чимэгбаатар, МУБИС З.Мөнхбаатар, МУБИС

Аннотация: Редким культурным наследием монгольского языка является одно из замечательных произведений монгольского древнего письменного памятника “Секретное Сокровище Монголии”. Тщательное изучение структуры, значения и состава каждого предложения данного сокровища позволяет нам сделать вывод о том, что оно включает в себя довольно большое количество фразеологических слов и выражений, отражающих национально-специфические особенности монгольского быта, неповторимый колорит сознания и мышления монголов, обусловленных кочевым образом жизни.

Түлхүүр үг: Хэл, хэлэхүй, үндэсний дархлаа бүхий үг хэллэг, хэллэгийн утга ба бүтэц

Удиртгал

Монголын түүх, уран зохиолын ноён оргилын нэг “Монголын нууц товчоо” зохиол нь олон жилийн турш гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн судалгаа шинжилгээний арвин сан хөмрөгийн нэг билээ. Учир нь энэ зохиолыг монгол хүн монгол газар нутагт зохиосон тул гадаадын түүхэн зохиолуудаас онцын ялгаатай үндэстний бүтээл болж уламжилсан байна. (Дамдинсүрэн, 1990, х.3)

“Монголын Нууц Товчоо” зохиолыг гадаад, дотоодын олон эрдэмтэн судалж, судалгааны бүтээлээ хэвлүүлснээс Оросын монголч эрдэмтэн А.П. Кафаров, Н.А. Позднеев, С.А. Козин, Б.Я.Владимирцов, Германы эрдэмтэн Э.Хэниш, Францын эрдэмтэн Пелльо, монголын эрдэмтэн Х.Пэрлээ, Ш.Гаадамба, Ц.Дамдинсүрэн нарын судалгаа үнэтэй хувь нэмэр оруулжээ. Эдгээр эрдэмтэн уг зохиолыг түүхэн үндэс, уран зохиолын дурсгал болох талаас нь тусгайлан судалсан байна.

Сүүлийн үед энэхүү зохиол дахь дүр, дүрслэл, бэлгэдэлзүй, утгазүй болон хэлзүйнталаарх судалгаа судлаачдын анхаарлыг татах болов.

Бид энэхүү өгүүлэлдээ “Монголын нууц товчоо” зохиол дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийн онцлог, түүгээр монголчуудын үндэсний сэтгэлгээ, амьдралын хэв маяг, хэл, соёл, түүх хэрхэн илэрч байгааг судлахын зэрэгцээ зохиол дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийг аман

зохиолын төрөл зүйлүүдэд ангилан, илэрхийлж буй утга санаа, хэлзүйн хэлбэржилт бүтцийн талаас нь задлан шинжилж, нэгтгэн дүгнэхийг зорилоо.

Монгол хэл нь үндэстнийхээ сэтгэлгээ, зан үйл, нүүдэлчин амьдралын хэв маягийг илэрхийлсэн хэлц үг, хэллэгээр арвин баялаг бөгөөд энэ нь хэлний дархлааг буй болгож буй хүчин зүйлийн нэг юм. Үүгээрээ ч хэлц хэллэг нь эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын гол объект болсоор байна. Монгол хэлний хэлц үг, хэллэгийн талаар дагнан бичсэн судлаачдын бүтээлүүд нь тэдгээрийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан байна. Тухайлбал, хэлц үг хэллэгийн талаар эрдэмтэн, судлаач Д.Бадамдорж, Б.Пүрэв-Очир, М.Базаррагчаа, Ж.Баянсан, Б. Баттогтох нар хэрэглээ, утга, орны талаас нь голлож, эрдэмтэн Г.Аким, Л.Дашням, Ж.Бат-Ирээдүй нар толиллох, зүйлчлэх талаас нь тус тус судалжээ. Ж.Бат-Ирээдүй “Монгол хэлний хэлц нэгжийн тогтолцооны тухай асуудалд” өгүүлэлдээ: “... Аливаа хэлний хэлц нь олон мянган жилийн хөгжлийн үр дүнд боловсрон бий болж, хэвшин тогтдог, тухайн ард түмний аж амьдрал, ахуй орчин, зан заншил, соёл, сэтгэлгээний онцлогийг тусгадаг нэгэн төрлийн өвөрмөц, бэхжмэл цул бүтэц юм.

Монгол хэлний хувьд хэлцээр маш баян бөгөөд тогтвортой нэгжүүдийг хэдийгээр олон янзаар нэрлэдэг боловч хэлц үг, хэлц хэллэг, хэлц үгүүлбэр гэх мэтээр нэрлэж хэвшээд байна. (2009, х3) гэж дүгнэжээ.

Үндсэн хэсэг

Нэг. “Монголын Нууц Товчоо” зохиол дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийн утга, ба хэлзүйн онцлог

“Монголын нууц товчоо” зохиол дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийг түүвэрлэн жагсааж утгыг тайлбарлавал:

1. Нөхөр шорлогдоо /13-р зүйл/-Ангийн хишиг хүртээх ёсыг хэлдэг байв.
2. Тэр хүн, гарах нар сарны хилээр шарвалзсаар гарч одно. /21-р зүйл/-Өглөө эрт үүрээр гарах
3. Хар тэргүүт хүнтэй адилтгаж яахан болно. /21-р зүйл/-Эгэл ардтай адилтгаж болохгүй.

4. Бие тэргүүтэй, дээл захтай нь сайн. /33-р зүйл/-Ахас ихэсээ мэдэж байх.
5. Тугаарын Түнхэлэг горхиноо бүхий иргэнд эзэнгүй, их бага, сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацуу байна. /35-р зүйл/- удирдагч, толгойлогчгүй байх
6. Таван хурууны хумсыг тамтартал, арван хуруугаа барагдтал. /53-р зүйл/- Эцсийн хүчээ шавхах
7. Хайвал мөргүй, харвал бараагүй. /56-р зүйл/- Ор сураггүй болох
8. Хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл /57-р зүйл/-Аливаа зүйлийг хэмжээнээс нь хэтрүүлэн хийх.
9. Нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой. /62-р зүйл/- Сэргэлэн цовоо, цог золбоотой байх
10. Зээгийн зүсээр, охидын өнгөөр явна. / 64-р зүйл / - гоо сайхныг эрхэмлэх
11. Нуган хүүхэд нутгаа эзэмшинэ. /65-р зүйл/- Эр хүн удам залгаж нутагтаа эзэн болдог.
12. Охин хүүхэд өнгө шилэгдэнэ. /65-р зүйл/- Бүсгүй хүн хүний хүн болж амьдрах заяатай байдаг гэсэн санаатай.
13. Охин хүний заяа төрсөн үүдэнд өтлөхгүй. /66-р зүйл/- бүсгүй хүн төрсөн гэрээ орхиж явдаг.
14. Цээлийн ус ширгэв
Цэгээн чулуу хагарав. /72-р зүйл/- Нэгдэлтэй байсан нэгэн овог аймаг тарж бутарсныг дүрсэлсэн. Өөрөөр хэлбэл, эв түнжин эвдэрч, тарж бутрах гэсэн утгатай.
15. Сүүдрээс өөр нөхөргүй
Сүүлнээс өөр ташуургүй /76-р зүйл/- Тулж түших найз нөхөдгүй болж, ганцаардах
16. Нүдний сормуус, амны бөөлжис болгох /77-р зүйл/- ад шоо үзэх, гадуурхах, доромжлох
17. Хурганы үс гуужив.
Төлөгний үс төлжив. /79-р зүйл/- Эр өсөж, эсгий сунах. Эрийн цээнд хүрэх, өсөж том болох
18. Усанд чилмий үгүй, огторгуйд мөр үгүй /82-р зүйл/- Ор мөргүй алга болох
19. Ам шүдээ билүүдэх. /82-р зүйл/- өс санах, уураа даран ядах
20. Үнсээр хийсгэн алдах - /86-р зүйл/- үнхэлцгээ хагартал айх, ихэд айж түгших
21. Бөөр нь бөгсөнд байг, цэр нь цээжинд байг. /96-р зүйл/- Ах захтай байх
22. Эмээлээ тохуул, үүдээ сөхүүл - /97-р зүйл/- Зарц боолоо болгох
23. Бөөсөн чинээ амь, бөөрийн чинээ бие /103-р зүйл/- өчүүхэн амь нас, бие
24. Бороо тохиолдовч болзооноос хождохгүй, хур тохиолдовч хурлаас саатахгүй. /108-р зүйл/- Цагийн юм цагтаа дээр
25. Ууланд шахан бууя, адуучинд гэр болтугай.
Голд шахан бууя, хоньчин хургачин нарт хоол болтугай. /118-р зүйл/- Тус тусдаа амьдрах, салан тусгаарлах гэсэн санаа
26. Хүч түрэмгийлэгчдийн хүзүүг хянгардаж, омог ихтний омрууг огтлох. /124-р зүйл/- номхотгох, зүрхийг нь үхүүлэх
27. Нөмрөх эсгий мэт нөхөөс бамбай болох /124-зүйл/- зовох цагт нөхрийн чанар танигдана. Сайн найз, дотны туслагч байх.
28. Үүдний чинь өмч болтугай! /137-р зүйл/- Үнэнч боол болох.
29. Өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгох- /138-р зүйл/- Дотны туслагч, үнэнч боолоо болгох
30. Тэнгэр хилэн болох.-/143-р зүйл/- муу зүйл тохиолдох
31. Дотор минь саруул болов. - /145-р зүйл/- санаа амрах, амгалан болох
32. Алд бие /147-р зүйл/- Биеэ бага гэж үзэх
33. Бор зүрх минь бол бол хийж, богино хавирга шир шир хийх. /149-р зүйл/- айж эмээх, айсан хүнд аргал хөдлөх.
34. Зүү мэт жирвэлзэж, утас мэт улалзах.-/149-р зүйл/- сонор сэрэмжтэй байх, хянуур гярхай байх.
35. Харвах сумны халхавч болж, хангинах зэвийн бамбай болох /149-зүйл/- Итгэлт сайн хамгаалагч байх, дотны туслагч.
36. Дэр хийж үхэх /151-р зүйл/- Амьд хүний гэрч болсноос үхсэн хүний дэр бол.
37. Үүнийгээ үнсээр хийсгэх үмхий санаа өвөртөлсөн байна. /151-р зүйл/- Санаа муутай байх
38. Ханат гэрээс салж, хадат гэрт очих. /164-р зүйл/- Нас барах, хадан гэртээ очих.
39. Араат могойн шүд амрагийн хооронд орох. /164-р зүйл/- Хоёр хүний хооронд яс хаях, муудалцуулах
40. Уртын үзүүр, гүний ёроолд хүрэхээс буцахгүй./166-р зүйл/- үхэн үхтлээ үнэнч зүтгэх
41. Амьд хүн ам хэлээрээ./167-р зүйл/- Хүн хэлээрээ мал хөлөөрөө.
42. Цагаан идээнд цацаж, хар маханд хахах. /167-р зүйл/-нас барах, мөнх бусыг үзүүлэх
43. Дэлэм үг, алд хэл /169-р зүйл/- Илүү үгтэй байх, хэрэгтэй хэрэггүй дэл сул үгтэй байх.
44. Хэлээ татаж, амаа барих - /196-р зүйл/-үгээ цэнэж явах.
45. Морин унаатан, модон нөмөртөн болов.

- /174-р зүйл/- Модоо барих, хоосрох, юу ч үгүй болох.
46. Жирэмсэн эмийн шээх газраас хол яваагүй, жижиг тугалын бэлчих газраас гарч үзээгүй. /194-р зүйл/- Аймхай, дорой байх, туулай зүрх гаргах.
47. Шүүдрээр унд хийж, шүлсээр хоол хийх -/195-р зүйл/- Амьд хүн аргатай. Зорьсон үйлсээ бүтээхийн тулд арга саам бүхнийг хайх.
48. Харанхуй шөнө халдах чоно болж, гэгээн өдөр хэсэх хэрээ болох. /210-р зүйл/- Итгэлт нөхөр, үнэнч боол болох
49. Хүзүүнээс нь татаж хүний зэрэг болгох, эгмээс нь татаж эрийн зэрэгт хүргэх /214-р зүйл/- Эх хүний ач буян, эхийн санаа үрд.
50. Харайхад хөл болж, хазайхад түшиг болох. /235-р зүйл/-түшиг тулгуур болох сайн туслагч, дотны нөхөр
51. Сүлд гэгээн бие сүүдэр болж одох. /245-р зүйл/- нас барах, үгүй болох
52. Байсан газартаа байран нутагладаг, шавар хотдоо шавалдан суудаг. /249-р зүйл/- Тангуд иргэний байр байдлыг ёгтлон хэлсэн.
53. Амаар алсныг ачиж болдоггүй, үгээр үхүүлснийг өвчиж болдоггүй. /255-р зүйл/- Ам алдвал барьж болдоггүй.
54. Өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй, өөхөнд ороовч нохой тоож шиншлэхгүй юм төрөөд хандгайг харвах гээд оготныг онох. /255-р зүйл/- Хойч үеийн үр ач нар хэнд ч хэрэггүй юм болж улс орон эзэнгүйдэх болуузай гэж Өгөөдэй Чингис хаанд сануулан хэлдэг.
55. Баруун гар болох. /255-р зүйл/- үнэнч нөхөр, туслагч
56. Хөл хөсөр, гар газар тавиулах. /281-р зүйл/- амар амгалан, төвшин болгох.
57. Өврөө дулаацуулж, хөлөө хучуулах. /208-р зүйл/- ханийн сэтгэл хязгааргүй.
58. Тэнгэр ятгах /80-р зүйл/- зөн совин татах
59. Өр өвтгөх/105-р зүйл/- айлгаж түгшээх.
60. Элэг зүрхийг эмтлэх /113-р зүйл/- өнчрөх, / мэргэд иргэнийг дайран довтолж, эзэлсэн
61. Хөвчин улс/254-р зүйл/- олон хүн, ард олон
62. Хэлсэн үгэндээ хүрч ардын инээдэм, амьтны тоглоом болохгүй байх /255-р зүйл/- хэлсэн үгэндээ эзэн болох
- “Монголын Нууц Товчоо” зохиол дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийг түүвэрлэн нэгтгэвэл нийт 62 өгүүлбэр байна. Эдгээр өгүүлбэрийг өгүүлж буй өгүүлэгчийн зүгээс нь *ахуй амьдрал, эзэн боолын харилцаа, анд нөхдийн харилцаа, хүний хувь заяа, эв нэгдэл, хүний зан төлөв, сургамж үг, зан үйл* гэсэн найман зүйлээр сэдэвчлэн тоон

статистик аргаар дүгнэвэл дараах байдалтай болж байна. Үүнд:

Хүснэгт 1

Хэлц өгүүлбэрүүдийг сэдвээр зүйлчилсэн нь

№	Сэдэв	Тоо	Хувь
1	Ахуй амьдрал	5	8%
2	Эзэн боолын харилцаа	12	19%
3	Хүний хувь заяа	7	11%
4	Эв нэгдэл	9	14%
5	Анд нөхдийн харилцаа	11	17%
6	Хүний зан төлөв	4	6%
7	Сургамж үг	8	12%
8	Зан үйл	8	12%

Дээрх хүснэгтээс дүгнэхэд, эзэн боолын , анд нөхдийн болон эв нэгдлийн харилцаагаар илэрч буй хэлц хэллэг бүхий өгүүлбэр зонхилж байгаа нь эзэнт гүрний үеийн нийгмийн мөн чанарыг тодотгож байна. Өөрөөр хэлбэл, эртний монголчуудын амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзлийн тусгал болжээ.

Нөгөө талаар, дээрх өгүүлбэр нь уг зохиолын уран дүрслэлийн онцлогийг илэрхийлж, уран сайхны чимэг болохын зэрэгцээ монголын уран зохиолд хэлц хэллэгийн үүрэг, учир холбогдол нэн эртний уламжлалтай болохыг харуулж байна.

Мөн зохиол дахь хэлц өгүүлбэрүүд нь ... **Хурганы үс гуужив. Төлөгний үс төлжив.** гэх мэтээр монгол ахуй, ёс заншил, ухамсрыг тусгасан үндэсний сэтгэлгээ бүхий үг хэллэгээр арвин байна.

Хоёр. “Монголын Нууц Товчоо” дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийн утгазүйн онцлог.

1. Ойролцоо утгат хэлц өгүүлбэр

- *Хүн ахтай дээл захтай*
 - Бие тэргүүтэй, дээл захтай нь сайн.
 - Тугаарын Түнхэлэг горхиноо бүхий иргэнд эзэнгүй их, бага, сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацуу байна.
 - Бөөр нь бөгсөнд, цэр нь цээжинд байг.
- *Нүдэндээ галтай нүүрэндээ цогтой байх*
 - Энэ хөвүүн чинь нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой хөвүүн байна.
 - Зээгийн зүсээр, охидын өнгөөр явна.
 - Нуган хүүхэд нутгаа эзэмшинэ.
 - Охин хүүхэд өнгө шилэгдэнэ.
 - Эрхийдээ эрчимтэй
 - Элгэндээ шүүстэй
 - Уушгиндаа ууртай

Уруулдаа хилэнтэй хүчит бөх ба эрдэмт эрсийг ялгаж хүүдээ өгөв.

- *Төрсний эцэст үхэх үнэн*
 - Хан Тоорил би ханат гэрээс салж, хадат гэрт очвол хамаг хураасан улсыг минь харж хамгаалж байх хүн хаана хэн байх билээ.
 - Хамгийн хаан, улсын эзэн минь Харцгай шувууны жигүүр болон одов Хангинах тэрэгний тээш болон одов Жиргэх шувууны жигүүр болон одов Жигдрэх тэрэгний ачаа болон одов
- *Сайн нөхөр саднаас дээр*
 - Хулгана оготно мэт хураасан хөрөнгийг хадгалж, хар хэрээ мэт хамаг юмыг харамлаж, нөмрөх эсгий мэт нөхөөс бамбай болж, гэр орныг хамгаалж, хэрсгээ бүрээс больё!
 - Босгын чинь боол болтугай Үүдний чинь өмч болтугай.
 - Харвах сумны халхавч болж, хангинах зэвийн бамбай болж, итгэлт эзэн чиний идэт биенд ирт мэс бүү хүргэе! Харайхад минь хөл болж, хазайхад минь түшиг болох
- *Өсийг өсөөр*
 - Таван хурууны хумсыг тамтартал, арван хуруугаа барагдтал миний өшөөг авахыг оролдогтун.
 - Ах дүү Тайчууд нар ам шүдээ билүүдэн айсуу явна.

2. “Монголын Нууц Товчоо” дахь хэлц өгүүлбэрийг МААЗ-ын зүйр цэцэн үгийн төрөл зүйлээр ангилах нь

- **Зүйр үгийн зүйл**
 - Бие тэргүүтэй
Дээл захтай нь сайн
 - Тул загас мэт тулбиран гаслах
Усны загас мэт уяран гаслах
 - Гэдрэг довтлох хэрцгий цөөвөр мэт
 - Хурганы үс гуужих
Төлөгний үс төлжих
 - Шүүдрээр унд хийж, шүлсээр хоол хийх
 - Салхиар унаа хийж, саадгаар нөхөр хийх гэх мэт
- **Мэргэн үгийн зүйл**
 - Охин хүний заяа төрсөн үүдэнд өтлөхгүй
 - Сүүдрээс өөр нөхөргүй


Сүүлнээс өөр ташуургүй

- Усанд чилмий үгүй, огторгуйд мөр үгүй
- Бороо тохиолдовч болзооноос хождохгүй
Хур тохиолдовч хурлаас саатахгүй
- Ууланд шахан бууя
Адуучинд гэр болтугай
Голд шахан бууя хоньчин, хургачин нарт хоол болтугай.
- Байсан газартаа байран нутагладаг
Шавар хотондоо шавалдан суудаг
- Амьд хүн ам хэлээрээ
- Дэлэм үг, алд хэл
- Хэлээ татаж, амаа барьж явах
- Морин унаатан, модон нөмөртөн
- Жирэмсэн эмийн шээх газраас хол яваагүй
Жижиг тугалын бэлчих бэлчээрээс гарч үзээгүй.
- Хүзүүнээс нь татаж хүний зэрэг болгох
Эгмээс нь татаж эрийн зэрэг болгох.
гэх мэт

• Цэцэн үгийн зүйл

- Бөөр нь бөгсөнд байг
Цэр нь цээжинд байг
- Таван хурууны хумсыг тамтартал, арван хуруугаа барагдтал.
- Хайвал мөргүй, харвал бараагүй.
- Нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой.
- Зээгийн зүсээр, охины өнгөөр
- Нуган хүүхэд нутгаа эзэмшинэ. Охин хүүхэд өнгө шилэгдэнэ.
- Цээлийн ус ширгэв. Цэгээн чулуу хагарах. гэх мэт

График 1. МААЗ-ын зүйр цэцэн үгийн төрлөөр ангилсан нь



Ийнхүү зохиолд гарч буй хэлц хэллэг бүхийг өгүүлбэрүүдийг хэлний утгын харьцаагаар нь ангилан авч үзэхэд, ойролцоо утгат хэллэг бүхий өгүүлбэр зонхилж байна. Энэ нь эртний монголчууд юм үзэгдэл, үйл явдлаар илрэх утга агуулгыг олон янзаар хэлж ярих сэтгэхүйн

өвөрмөц онцлогтой ард түмэн гэдгийг харуулж байна.

- Мөн зохиолд гарч буй хэлц хэллэг бүхий өгүүлбэрийг МААЗ-ын зүйр цэцэн үгийн төрөлд тулгуурлан зүйлчлэн ангилвал, зүйр үгийн чанартай үг хэллэг илүү байгаа нь монгол хүний зүйрлэн хэлэх, ярих чадвар, нүүдэлчдийн ахуй соёл, сэтгэлгээний онцлогийг нотлон илэрхийлж байна.

Гурав. “Монголын Нууц Товчоо” дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийн хэлзүйн хэлбэржилт, бүтэц, утгын нэгдлийг харгалзуулан авч үзье.

“Монголын Нууц товчоо” дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийг хэлзүйн хэлбэржилт, өгүүлбэрзүйн бүтцийн талаас нь нэгтгэн авч үзэхэд:

Энгийн бүтэцтэй өгүүлбэр-27, нийлмэл бүтэцтэй өгүүлбэр – 33 байна.

Эдгээрийг хэлний хэлзүй болон утгын нэгдэлд нь харгалзуулан дараах байдлаар тайлбарлах боломж байна. Үүнд:

1. *Хэрэв хан эцэг чамайг цагаан идээнд цацаж, хар маханд хахваас зовж хураасан улсыг тань мэдүүлэхгүй болуузай.*

Дээрх өгүүлбэр нь “Цагаан идээнд цацах, Хар маханд хахах” гэсэн бие даасан утгатай хоёр өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбох –ж нөхцөлөөр хэлбэржүүлэн холбож, “үхэх, үгүй болох” гэсэн санаагаар утга шилжүүлэн “Зовж хураасан улс” гэсэн тодотгогч, тодотгуулагчийн харьцаа бүхий гишүүн өгүүлбэрт захируулан “Мэдүүлэхгүй болуузай” гэсэн сануулсан баймж бүхий эзэн биегүй нэг бүрэлдэхүүнт гол өгүүлбэрт захируулж бүтсэн байна. Энд байгаа “хэрэв” гэсэн холбох үгээр тухайн хэлэх гэсэн санааг лавшруулан онцолсон баймж илэрсэн бөгөөд өгүүлбэр нь утгын хувьд бүхэлдээ үгийн утга шилжүүлэн далд санааг агуулсан хэлц өгүүлбэрийн шинжтэй байна.

Өгүүлбэрийн гол утга нь:

Хэрэйдийн ван хан Тоорилын хүү нялх Сэнгүм эцгээ нас барсны дараа Тэмүжинд улсаа алдах вий гэсэн болгоомжлол, хар сэтгэлийг илэрхийлж байна.

2. *Хойч үеийн хөвгүүд ач нар минь өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй, өөхөнд ороовч нохой тоож шинилэхгүй юм төрөөд хандгайг харвах гээд оготныг онох болуузай.*

Энэ өгүүлбэрт “Өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй. Өөхөнд ороовч нохой тоож шинилэхгүй” гэсэн энгийн өгүүлбэрүүдийг хэлэх аялгаар зэрэгцүүлэн найруулж, гол өгүүлбэрийн “юм” гэсэн үйлийн эзэн биеийг тодотгох үүргээр дэлгэрүүлэн холбожээ. “Юм” гэсэн гишүүн нь “хөвгүүд, ач нар” гэсэн өгүүлэгдэхүүн гишүүнийг онцолж, онцолбор гишүүний үүргээр хэрэглэгдсэн бөгөөд чамлаж, болгоомжилсон баймж бүхий санааг илтгэж байна.

Мөн дээрх өгүүлбэрт буй “Хандгайг харвах гээд оготныг онох болуузай” гэсэн хэллэгээр хойч үеийн үр ач нар минь хэнд ч хэрэггүй үйлсгүй хүмүүс болох вий гэсэн болгоомжлол, алтан ургийн хэлхээг цэвэр ариун байлгаж, хойч үедээ өвлүүлэх чин санааг илэрхийлж байна. Гол өгүүлбэр нь: *Хойч үеийн хөвгүүд ач нар минь / юм/ төрөөд, хандгайг харвах гээд оготныг онох болуузай* гэсэн хэлхээ энгийн өгүүлбэрээр илэрч, “Өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй. Өөхөнд ороовч нохой тоож шинилэхгүй” гэсэн хэлц хэллэг бүхий өгүүлбэрээр дэлгэрсэн байна. Энэ нь монгол хэлний өгүүлбэрийн бүтцэд хэлц ба хэлц бус нэгжүүд хамтран орж утга санааг илэрхийлдэг өвөрмөц онцлогтойг харуулж байна.

3. *Бөөр нь бөгсөнд байг, цэр нь чээжинд байг.*

Өгүүлбэрийн гол утга нь “Ах захтай байх” гэсэн санааг аливаа юм байвал зохих байрандаа байх ёстой гэсэн дэд утгаар илэрхийлэхдээ бие эрхтэнд байдаг бөөр, цэр гэсэн зүйлээр зүйрлэн утга шилжүүлэн хэрэглэжээ.

Хэлзүйн хэлбэржилтийн хувьд “Бөөр бөгсөнд байдаг. Цэр чээжинд байдаг.” гэсэн хоёр энгийн өгүүлбэрийг үйлийн 2-р биед шууд захирах хүсэх төлөвийн –г нөхцөлөөр салаалан хувиргаж, захирсан өнгө аяс бүхий зэрэгцсэн хэллэг өгүүлбэр бүтсэн байна.

4. *Цээлийн ус ширгэв, цэгээн чулуу хагарав.*

Энэхүү өгүүлбэр нь нэгдсэн нэг овог аймгийн хагарал бутралын явцыг илэрхийлсэн далд санаа бүхий хэлц өгүүлбэр бөгөөд тухайн хэрэг явдлыг *ус ширгэх, чулуу хагарах* гэсэн байгалийн юм үзэгдлийн хувирал өөрчлөлттэй эн зэрэгцүүлэн зүйрлэж, өнгөрсөн цагийн –в нөхцөлөөр хэлбэржүүлэн хэлэх нэгэн аялгад захируулан бүтсэн байна.

Өөрөөр хэлбэл, байгалийн хоёр өөр үзэгдэл, үйл явдлаар нэгэн аймгийн хагарал, бутрал, эв түнжингүй байдлыг илэрхийлсэн ойролцоо зэргэд өгүүлбэр болж байна.

Ийнхүү “Монголын Нууц Товчоо” дахь хэлц өгүүлбэрийг бүтэц, хэв шинжийн талаас нь задлан нэгтгэвэл, монгол хэлний энгийн ба нийлмэл өгүүлбэрийн бүх хэв шинж түгээмэл байх бөгөөд энгийн өгүүлбэрийн хүрээнд зохиол дахь нийт хэлц энгийн өгүүлбэрийн хэв шинж нь бүрэлдэхүүнийхээ талаас нэг, хоёр, гурван бүрэлдэхүүнт өгүүлбэр, хэлэхүй талаасаа хүүрнэх, хэв маягийн талаасаа хэлхэц, утгын талаасаа ойролцоо утгат өгүүлбэр зонхилж байна.

Нийлмэл бүтэцтэй өгүүлбэр нь энгийн өгүүлбэрээс тооны хувьд харьцангуй олон оржээ. Энэ нь монголчууд эртнээс хэл яриандаа энгийн хялбар бүтэцтэй өгүүлбэр хэрэглэхээс илүүтэй юм үзэгдэл, үйл явдлыг илэрхийлэхдээ энгийнээс гүн рүү ургуулан сэтгэж өгүүлдэг байсны гэрч юм.

Ер нь “Монголын Нууц Товчоо” дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрүүд нь хэлзүйн холбоо харьцаа, арга хэрэглүүр, утгазүйн хувьд нягт шүтэлцээтэй байдаг нь монголчуудын хэлц хэллэгийн арвин баялаг сан, нүүдэлчдийн ахуй соёлын ололтын илэрхийлэл болж байна.

Судалгааны үр дүн:

“Монголын Нууц Товчоо” зохиол дахь хэлц хэллэг бүхий өгүүлбэрийг утга, бүтэц, үгийн сангийн бүрэлдэхүүн, аман зохиолын зүйр цэцэн үгийн төрөл болох талаас нь судлахад уг зохиол монголын түүх, уран зохиолын үнэт дурсгал болох төдийгүй үндэсний өв соёл, эх хэлний хэлзүй, утгазүйн судалгааны баялаг судлагдахуун болох нь тодорхой байна.

ДҮГНЭЛТ

Монголын эртний бичгийн дурсгалын ноён оргил болох “Монголын Нууц Товчоо” зохиол нь монгол хэл, соёлын нандин өв уламжлал бөгөөд үүгээрээ монгол үндэстний ахуй, ухамсар, сэтгэлгээ, зан заншлын өвөрмөц онцлогийг тусгасан хэлц үг, хэллэгийн арвин сантай болох нь уг зохиол дахь хэлц өгүүлбэрийн утга, үүрэг, хэрэглээ, өгүүлбэрийн хэлзүйн бүтэц, утгын нэгдлийг задлан шинжлэхэд харагдаж байна.

Монгол үндэстний бахархал болсон энэхүү зохиолыг хэлзүйн бүтэц, утгазүйн онцлог талаас нь судлах нь эх хэлээ эрхэмлэн дээдлэх, дархлааг нь бэхжүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх зэрэг олон талын ач холбогдолтой юм. Иймээс уг зохиолыг хэлний хэлзүй, утга судлалын талаас нь цаашид нарийвчлан судалж, эх хэл, соёл түүхийн сургалтад нэвтрүүлэх өргөн боломж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бат-Ирээдүй, Ж. (2009). *Монгол хэлний хэлц үгийн сан*. Улаанбаатар
- Бат-Ирээдүй, Ж. (2007). *Монгол хэлний хэлвснэмэл хэллэг дэх хэлц үгийн утга*. Улаанбаатар
- Бат-Ирээдүй, Ж. (2013). *Монгол хэл бичиг, утга, соёл хэрэглээ*. Улаанбаатар: Мөнхийн Үсэг.
- Бат-Ирээдүй, Ж. (2010). *Монгол хэлний үг, утгын сан*. Улаанбаатар: Адмон
- Бат-Ирээдүй, Ж., Алтансайхан, Р. (2013). *Монгол утга зохиол шинжлэлийн өгүүлэлзүй*. Улаанбаатар
- Баттогтох, Д. (2009). *Үгийн ширэнгээр бэдрэхүй*. Бээжин
- Билигсайхан, Ч. (2012). *Бичгийн мэргэдийн билгүүн товчоон*. Улаанбаатар
- Галбаатар, Д. (2012). *Уран зохиол, нэвтэрхий толь*. Улаанбаатар
- Дамдинсүрэн, Ц. (1990). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар
- Өлзийхутаг, Ц. (1973). *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар
- Пүрэв-Очир, Б. (2009). *Үг, өгүүлбэрийн амьдрал, араншин эрчим энерги, соёл хэрэглээ*. Улаанбаатар
- Хишигтогто, Ч. (2008). *Монголын эртний утга зохиолын шинэ судлал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Цэрэнсодном, Д. (1987). *Монгол уран зохиол*. Улаанбаатар
- Чулуунпүрэв, С., Одончимэг, Б. (2012). *Монгол хэлний хэвснэмэл хэлний толь*. Улаанбаатар: Монсудар
- Шагжжав, М. (2010). *Хэлц ба сургаал үгийн тайлал*. Улаанбаатар
- Янжиндолгор, А. (2014). *Монгол хэлний тайлбар толь*. Улаанбаатар: Монсудар